



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2016 оны 7 дугаар сар


Ерөнхий тойм: Оны эхний 7 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 12.9%-иар буюу 647.5 сая ам.доллараар буурч 4374.2 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 9.6%-иар буюу 271.3 сая ам.доллараар, импорт 17.0%-иар буюу 376.2 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 708.9 сая ам.доллараар давж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 104.9 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 7 сараар			Өөрчлөлт			
	2013	2014	2015	2014/2013		2015/2014		2014	2015	2016	2015/2014		2016/2015	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,627	11,011	8,467	384	3.6%	(2,544)	-23.1%	6,064	5,022	4,374.2	(1,043)	-17.2%	(647.5)	-12.9%
Экспорт	4,269	5,774	4,669	1,505	35.3%	(1,105)	-19.1%	2,940	2,813	2,542	(127)	-4.3%	(271.3)	-9.6%
Импорт	6,358	5,237	3,797	(1,121)	-17.6%	(1,440)	-27.5%	3,124	2,209	1,833	(916)	-29.3%	(376.2)	-17.0%
Тэнцэл	(2,089)	538	872	2,626		335	62.2%	(185)	604	708.9	789		104.9	17.4%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлтүүдийн нэг юм. 2010 оноос хойш тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны сүүлийн хагасаас ашигтай гарч эхэлсэн. Уг үзүүлэлт 2016 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 736.1 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 2.1 сая ам.доллараар буурсан байна.

Дүрслэл 1. Валютын төлбөртэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 60.5% буюу 2644.6 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 11.0% буюу 480.3 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 17.5%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 24.9%-иар тус тус буурсан байна.

Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Хүснэгт 2. Худалдааны нөхцөлийн индекс /2012 оны 12 сар суурьтай/

Үнийн индексийн төрөл*	2015.7 сар	2016.6 сар	2016.7 сар	Жил Δ	Сар Δ
Экспорт	0.94	0.72	0.69	-27%	-4%
Зэсийн баяжмал	0.51	0.32	0.30	-40%	-7.1%
Чулуун нүүрс	0.50	0.39	0.38	-24%	-1.9%
Ямааны угаасан ноолуур	0.41	0.34	0.33	-20%	-3.3%
Импорт	0.64	0.56	0.56	-12%	1%
Хэрэглээний бараа	0.78	0.77	0.77	-2%	0%
Хөрөнгө оруулалтын бараа	0.58	0.50	0.49	-14%	-1%
Нефтийн бүтээгдэхүүн	0.63	0.47	0.50	-21%	7%
Худалдааны нөхцөл	1.47	1.29	1.22	-17%	-5%

* Индексийн өөрчлөлтөд голлох хувь нэмэр оруулсан бараагаар задлав.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 16.8%-иар, өмнөх сараас 5.3%-иар буурч 1.221-д хүрлээ. Тайлант сард голлох импортын үнэ өссөн, зэсийн баяжмалын экспортын үнэ буурснаас худалдааны нөхцөл өмнөх сараас буурсан байна.

Экспортын гадаад худалдаа 2016 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 9.6%-иар буюу 271.3 сая ам.доллараар буурсан. Экспортын бууралтыг ерөнхий ангиллаар задалбал аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын өсөлт нь нийт экспортыг 0.3%-иар өсөхөд нөлөөлсөн ч, уул уурхайн түүхий эдийн экспортын бууралт нь нийт экспортыг 8.2%-иар буурахад нөлөөлжээ. Улмаар уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 0.1 нэгж хувиар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний жин 0.8 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Экспортын гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%2	Дүн	Өсөлт	%2
1. Уул уурхай		2,565	87%		2,412	86%		2,181	86%	(153)	-6%	-5%	(231)	-10%	-8.2%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	703	1,185	40%	784	1,353	48%	947	1,037	41%	168	14%	6%	(316)	-23%	-11%
1.2. Чулуун нүүрс	10,381	503	17%	8,114	353	13%	10,997	337	13%	(150)	-30%	-5%	(16)	-5%	-1%
1.3. Боловсруулаагүй нефть	3,781	380	13%	4,504	234	8%	4,772	186	7%	(146)	-38%	-5%	(48)	-21%	-2%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	3,072	240	8%	2,676	135	5%	3,476	132	5%	(105)	-44%	-4%	(2)	-2%	0%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	3,167	132	5%	4,636	180	6%	8,511	341	13%	48	36%	2%	162	90%	6%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	53	58	2%	65	81	3%	77	83	3%	24	41%	1%	1	2%	0%
1.7. Жонош, лейцит, нефелинт	177	39	1%	162	38	1%	137	32	1%	(2)	-4%	0%	(6)	-16%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	14	0%	3	20	1%	3	14	1%	6	39%	0%	(6)	-28%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	6	0%	1	7	0%	1	5	0%	1	13%	0%	(2)	-33%	0%
1.10. Мөнгө /тонн/	12	5	0%	42	9	0%	29	12	0%	5	0%	0%	3	35%	0%
1.11. Бусад	18	2	0%	48	1	0%	51	1	0%	(0)	-26%	0%	(0)	0%	0%
2. Мал аж, ахуй		273	9%		247	9%		209	8%	(27)	-10%	-1%	(38)	-15%	-1.3%
2.1. Амьд мал, малын мах	1	1	0%	2	6	0%	3	6	0%	5	374%	0%	0	4%	0%
2.2. Арьс, шир	197	24	1%	162	18	1%	106	17	1%	(6)	-23%	0%	(1)	-8%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	5	0%	0	5	0%	0	4	0%	0	4%	0%	(1)	-25%	0%
2.4. Ноолуур	6	236	8%	6	208	7%	5	172	7%	(29)	-12%	-1%	(36)	-17%	-1%
2.5. Ноос, бусад үс, хялгас	5	7	0%	6	10	0%	6	10	0%	2	32%	0%	0	2%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	0	1	0%	0	236%	0%	0	149%	0%
3. Газар тариалан		15	1%		21	1%		12	0%	6	41%	0%	(9)	-44%	-0.3%
4. Аж үйлдвэрлэл		85	3%		132	5%		140	5%	46	54%	2%	8	6%	0.3%
4.1. Хүнс	0	2	0%	2	15	1%	3	17	1%	13	612%	0%	1	7%	0%
4.2. Ноолууран эдлэл	0	10	0%	0	11	0%	0	10	0%	1	11%	0%	(2)	-15%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	4	0%	0	5	0%	1	7	0%	1	31%	0%	2	37%	0%
4.4. Уул уурхай	7	16	1%	25	50	2%	15	38	2%	34	208%	1%	(11)	-23%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	3	0%	0	1	0%	0	1	0%	(2)	-55%	0%	(1)	-57%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	45	2%	1	45	2%	1	64	3%	(0)	-1%	0%	19	42%	1%
4.7. Бусад	157	5	0%	108	4	0%	126	4	0%	(1)	-22%	0%	0	5%	0%
5. Бусад		1	0%		2	0%		1	0%	0	23%	0%	(1)	-63%	0.0%
Нийт дүн		2,940		2,813			2,542			(127)	-4%		(271.3)	-9.6%	


% 2 - Нийт өсөлтөөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын гадаад худалдааны өөрчлөлт, 2016 он

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
1. Уул уурхай	466.4	-202%	(697.3)	302%	(230.9)	-10%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	179.3	-57%	(495.2)	157%	(316.0)	-23%
1.2. Чулуун нүүрс	88.2	-537%	(104.7)	637%	(16.4)	-5%
1.3. Боловсруулаагүй нефть	10.5	-22%	(58.5)	122%	(48.1)	-21%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	30.4		(32.9)		(2.5)	-2%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	155.5	96%	6.1	4%	161.6	90%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	12.7	860%	(11.2)	-760%	1.5	2%
1.7. Жонош, лейцит, нефелинт	(5.9)	99%	(0.1)	1%	(6.0)	-16%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3.1	-54%	(8.7)	154%	(5.6)	-28%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	(1.7)	73%	(0.6)	27%	(2.3)	-33%
1.10. Мөнгө /тонн/	(5.7)	-179%	9.0	279%	3.2	35%
1.11. Бусад	0.1	-18%	(0.4)	118%	(0.4)	0%
2. Мал аж, ахуй	(20.6)	54%	(17.4)	46%	(37.9)	-15%
2.2. Арьс, шир	(8.9)	643%	7.5	-543%	(1.4)	-8%
2.4. Ноолуур	(13.9)	39%	(22.2)	61%	(36.2)	-17%
3. Газар тариалан	(4.3)	46%	(5.1)	54%	(9.4)	-44%
4. Аж үйлдвэрлэл	(9.6)	-119%	17.6	219%	8.1	6%
5. Бусад	(0.1)	7%	(1.0)	93%	(1.0)	-63%
Нийт дүн	431.8		(703.1)		(271.3)	-10%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Дүрслэл 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2016 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 431.8 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 703.1 сая ам.доллараар буурсан байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл уул уурхайн түүхий эдийн экспорт тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалан 466.4 сая ам.доллараар өссөн хэдий ч үнийн бууралтаас шалтгаалж 697.3 сая ам.доллараар буурснаас нийт 230.9 сая ам.доллараар буурлаа.

МАН-н түүхий эдийн экспорт үнэ, тоо хэмжээ зэрэг буурснаас шалтгаалж 37.9 сая ам.доллараар буурсан байна. Харин машин, тоног төхөөрөмжийн экспортын өсөлтөөс голчлон шалтгаалж аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт 6%-иар буюу 8.1 сая ам.доллараар өсчээ.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны сарын дундаж үнэ 2016 оны 7-р сард 1,356 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 20%-иар, өнгөрсөн сараас 7%-иар өссөн байна. А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ тайлант сард харгалзан 4,864, 58 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 11%-иар буурсан, төмрийн хүдэр 9%-иар өссөн бол өнгөрсөн сартай харьцуулахад 5%-иар, 11%-иар тус тус өссөн байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 7 дугаар сард 31 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 11%-иар буурсан бол өмнөх сараас 6%-иар өссөн байна.

Импортын гадаад худалдаа 2016 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 17.0%-иар буюу 376.2 сая ам.доллараар буурсан. Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 9%-ийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 7%-ийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 6 нэгж хувиар өссөн бол нефтийн бүтээгдэхүүний жин 5 нэгж хувиар буурчээ.

Хүснэгт 5. Импортын гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%2	Дүн	Өсөлт	%2	
Хэрэглээний бүтээгдэхүүн		822	26%		647	29%		647	35%		(176)	-21%	-6%	1	0%	0%
Түргэн эдэлгээтэй	480	431	14%	421	359	16%	365	334	18%	(72)	-17%	-2%	(26)	-7%	-1%	
Хүнс	229	298	10%	212	246	11%	189	229	12%	(52)	-17%	-2%	(17)	-7%	-1%	
Эм, гариа	2	47	1%	1	41	2%	1	50	3%	(5)	-11%	0%	8	21%	0%	
Бусад түргэн эдэлгээтэй бараа	249	87	3%	208	72	3%	175	55	3%	(15)	-17%	0%	(17)	-24%	-1%	
Удаан эдэлгээтэй	100	391	13%	116	287	13%	66	314	17%	(104)	-27%	-3%	27	9%	1%	
Гутал, хувцас, цүнх	21	33	1%	27	26	1%	25	28	2%	(7)	-21%	0%	2	8%	0%	
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	42	77	2%	55	57	3%	11	59	3%	(20)	-27%	-1%	2	3%	0%	
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	236	8%	1	166	8%	0	191	10%	(70)	-30%	-2%	25	15%	1%	
Бусад удаан эдэлгээтэй бараа	36	45	1%	33	39	2%	30	36	2%	(7)	-15%	0%	(3)	-7%	0%	
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн		1,294	41%		822	37%		622	34%		(472)	-36%	-15%	(200)	-24%	-9%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	16	704	23%	10	419	19%	7	361	20%	(285)	-41%	-9%	(58)	-14%	-3%	
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	192	6%	1	74	3%	0	108	6%	(118)	-61%	-4%	33	45%	2%	
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	16	512	16%	10	345	16%	7	253	14%	(167)	-33%	-5%	(92)	-27%	-4%	
Барилгын материал	1,701	449	14%	1,045	297	13%	358	161	9%	(152)	-34%	-5%	(136)	-46%	-6%	
Хөрөнгө оруулалтын бусад бараа	53	140	4%	42	106	5%	22	100	5%	(34)	-24%	-1%	(6)	-5%	0%	
Аж үйлдвэрлэлийн орц		347	11%		309	14%		303	17%		(39)	-11%	-1%	(5)	-2%	0%
Хүнсний орц	43	23	1%	29	18	1%	155	44	2%	(5)	-21%	0%	26	140%	1%	
Химийн бүтээгдэхүүн	70	57	2%	80	58	3%	62	46	3%	2	3%	0%	(12)	-21%	-1%	
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	16	9	0%	10	9	0%	10	10	1%	0	3%	0%	1	7%	0%	
Цахилгаан эрчим хүч	1	69	2%	1	76	3%	1	71	4%	7	11%	0%	(5)	-6%	0%	
Металлын хүдэр, баяжмал болон хааядал	1	0	0%	0	1	0%	1	1	0%	1	185%	0%	0	47%	0%	
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	525	189	6%	489	145	7%	364	130	7%	(44)	-23%	-1%	(15)	-10%	-1%	
Нефтийн бүтээгдэхүүн		616	65%		639	41%		419	25%		(236)	-36%	-8%	(158)	-38%	-7%
Дизель түнш	365	368	12%	367	224	10%	211	118	6%	(143)	-39%	-5%	(106)	-47%	-5%	
АИ-92, АИ-95	164	179	6%	203	135	6%	152	88	5%	(44)	-25%	-1%	(46)	-34%	-2%	
А-80 болон бусад	86	104	3%	69	56	3%	56	51	3%	(48)	-46%	-2%	(6)	-10%	0%	
Бусад	3	10	0%	12	17	1%	35	3	0%	6	0%	0%	(14)	-10%	-1%	
Нийт дүн		3,124		2,209			1,833			(916)	-29.3%		(376)	-17%		


% 2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын гадаад худалдааны өөрчлөлт, 2016 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(166.9)		167.9		0.9	0%
Түргэн эдэлгээтэй	(60.5)	236%	34.9	-136%	(25.6)	-7%
Удаан эдэлгээтэй	(106.4)	-400%	133.0	500%	26.6	9%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	(422.0)	211%	222.3	-111%	(199.7)	-24%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	(207.2)	357%	149.1	-257%	(58.1)	-14%
Барилгын материал	(210.2)	155%	74.2	-55%	(135.9)	-46%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(4.6)	82%	(1.1)	18%	(5.7)	-5%
Аж үйлдвэрлэлийн орц	(33.9)	644%	28.6	-544%	(5.3)	-2%
Нефтийн бүтээгдэхүүн	(129.0)	82%	(29.2)	18%	(158.2)	-38%
Дизель түнш	(87.1)	82%	(19.0)	18%	(106.1)	-47%
АИ-92, АИ-95	(29.6)	64%	(16.8)	36%	(46.4)	-34%
А-80 болон бусад	(12.2)	217%	6.6	-117%	(5.7)	-10%
Бусад	1.8	-13%	(15.8)	113%	(14.0)	0%
Нийт дүн	(750.0)		373.8		(376)	-17%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Дүрслэл 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



Тойм тооцооллоос үзэхэд 2016 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр импортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс голлон шалтгаалж нийт дүнгээр 376 сая ам.доллараар буурчээ.

Бүлэг тус бүрээр авч үзвэл хэрэглээний бүтээгдэхүүний импорт автомашины импортын тоо хэмжээ буурсан хэдий ч үнэ нэмэгдсэнээс шалтгаалан уг бүлгийн импорт 0.9 сая ам.доллараар өсчээ.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 24%-иар буюу 199.7 сая ам.доллараар буурсан нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ болон үнэ зэрэг буурснаар уг бүлгийн импорт 38%-иар буюу 158.2 сая ам.доллараар буурчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2013 оноос эхлэн тогтмол буурч байна. Хилийн үнэ 2012 оны 12 сард тонн тутамд 1,270.5 ам.доллар байсан бол 2016 оны 7-р сарын байдлаар тонн тутамд 554.1 ам.долларт хүрээд байна.